



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/35

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5, 8.2, 12 дугаар зүйлийн 12.2, 16 дугаар зүйлийн 16.2, 16.8.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох” журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Анхбаяр(Аймгийн Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Ж.Батбилэг (Аймгийн ерөнхий мал зүйч)

Гишүүд:

Н.Эрдэнэ-Очир(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Мөнхжаргал (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Х.Дашням(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Т.Ариунболд(Хөдөө аж ахуйн их сургуулийн багш)

Сумдын засаг дарга нар

2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулах ажлын хэсгийн сумдад ажиллах маршрутыг хавсралтаар баталсугай.

3. Аймгийн Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулж, батлуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

4. Дээрх арга хэмжээний зардлыг хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Сумдын засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822110 70

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны
өдрийн 43 дугаар захирамжийн хавсралт



**МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛАН БАТЛУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН СУМДАД АЖИЛЛАХ МАРШРУТ**

1-дүгээр ажлын хэсэг

№	Сумын нэр	Ажиллах өдөр	Ажиллах цаг
1	Сайнцагаан	2023.01.24	14.00-18.00
2	Луус	2023.01.25	09.00-13.00
3	Хулд		14.00-18.00
4	Дэлгэрхангай	2023.01.26	09.00-12.30
5	Сайхан-Овоо		14.00-18.00
6	Эрдэнэдалай	2023.01.27	09.00-13.00
7	Адаацаг		14.00-18.00
8	Өлзийт	2023.01.28	09.00-13.00

2 дугаар ажлын хэсэг

№	Сумын нэр	Ажиллах өдөр	Ажиллах цаг
1	Дэлгэрцогт	2023.01.25	09.00-13.00
2	Дэрэн		14.00-18.00
3	Цагаандэлгэр	2023.01.26	09.00-12.30
4	Говь-Угтаал		14.00-18.00
5	Баянжаргалан	2023.01.27	09.00-13.00
6	Өндөршил		14.00-18.00
7	Гурвансайхан	2023.01.28	09.00-13.00